



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/343

Булган сум

Нийлүүлэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Ус, хөрс бохирдохоос сэргийлж авто зам дагуу болон жуулчид ихээр цуглардаг үзэсгэлэнт газар, нуурын эрэгт стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж байгуулах (Тэшиг сум Харгал нуур 10ш)” ажлын Багц №2 Тэшиг сумын Харгал нуурын эрэгт зуны улиралд ашиглах стандартын шаардлагад нийцсэн зөөврийн нойл худалдан авч байршуулах (9ш)” нийлүүлэгчээр шалгарсан “Дансран дүвчин” ХХК-тай 55,010,000 (тавин таван сая арван мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр)-д олгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Дансран дүвчин” ХХК-ийн захирал (М.Бадамсүрэн)-д даалгасугай.

3.Барааны гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Булган аймгийн Тэшиг сумын Засаг даргын тамгын газар (Б.Батсайхан), хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга) нарт тус тус даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010462

Сугар Ажил 2026 өдөр Doc/2026/Захирамж

Аймгийн Засаг даргын 2026 оны  
05 дугаар сарын 07 ны/ний өдрийн  
А/ЗНЗ дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоног	А.Гантөмөр
2	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Очирсүрэн
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Очирсүрэн А.Гантөмөр

--o00o--